



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 4/530

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Япон Улсын “Зүрх хамгаалах төсөл” ашгийн бус байгууллага хооронд 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



**МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГА ЭРХПЭХ ЗӨВШЕӨРЛӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТИЙН НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШЕӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшшийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Томита Хидэши Tomita Hideshi	Япон Улс	Эх, Хүхэдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв	Япон Улсын “Зурх хамгаалах тесэл”, ашгийн бус байгууллага	ГЭ002177	Хүхэдийн зурх судпал	Эмчлэх	2018.12.21-2018.12 /4 хоног/
2.	Хигаки Такashi Higaki Takashi	Япон Улс	Эх, Хүхэдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв	Япон Улсын “Зурх хамгаалах тесэл”, ашгийн бус байгууллага	ГЭ002178	Хүхэдийн зурх судпал	Эмчлэх	2018.12.21-2018.12 /4 хоног/
3.	Фукими Таканари Fujii Takanari	Япон Улс	Эх, Хүхэдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв	Япон Улсын “Зурх хамгаалах тесэл”, ашгийн бус байгууллага	ГЭ002179	Хүхэдийн зурх судпал	Эмчлэх	2018.12.21-2018.12 /4 хоног/
4.	Фукими Томоко Fujii Tomoko	Япон Улс	Эх, Хүхэдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв	Япон Улсын “Зурх хамгаалах тесэл”, ашгийн бус байгууллага	ГЭ002180	Мэдээгүйжүүлэг судпал	Эмчлэх	2018.12.21-2018.12 /4 хоног/

Эрүүл мэндийн сайд
2018 оны 11 сарын 14-ны өдри
//30 дугаар тушаалын хавра

Эрүүл мэндийн сайд

2018 оны 11 сарын 14-ны өдри

//30 дугаар тушаалын хавра



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 0/535

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүгийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох журам"-ын 5.6 дахь заалт, Дорнод аймгийн Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 2018/ШТ/299 дугаартай шийтгэх тогтоол, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1310 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нүүр амны их эмч Батдэлгэрийн Оюун-Эрдэнийн ИЭ0015087 сери, 0015087 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Нүүр амны их эмч Б.Оюун-Эрдэнийн эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох эрх үүстэл буюу 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Амарсайхан/, Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /О.Баярбаатар/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ





МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 8/534

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүгийн тухай хууль (2002 он)-ийн тусгай ангийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох журам"-ын 5.6 дахь заалт, Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 64 дүгээр шийтгэх тогтоол, Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1176 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Заншир овогт Пүрвээгийн Энхбаярын ИЭ0010204 сери, 0010204 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Хүний их эмч 3.Энхбаярын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох эрх үүстэл буюу 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Мөнхцэцэг/, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар /Ж.Од/, Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Б.Мөнхзуул/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ